

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

БАЙГУУЛЛАГЫН 2026 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН
(2026 оны эхний хагас жилийн гүйцэтгэлээр)

2026 оны 06 дугаар сарын 10

Улаанбаатар хот

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилто т түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт (хүрээгүй бол тайлбар)	Хувь
1	2	3	4	5	6	7	8
Нэг. Улаанбаатар хотын онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх, жуулчдын ая тухтай аялах, зорчих нөхцөлийг бүрдүүлнэ.							
1.1. "Жуулчдад зориулсан соёлын болон тусгай сонирхлын аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг тогтмол зохион байгуулж, аяллын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгох чиглэлээр:							
1	Арга хэмжээ-1.1.1 Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүдийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх	Нийслэлийн батлагдсан төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад хэрэгцээт мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгөх зорилготой жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүдийг Жанжин Д.Сүхбаатарын талбай, "Төв шуудан", "Чингис хаан" олон улсын нисэх онгоцны буудал, ХБНГУ-ын Фрайбург хотод байрлах "Монголын соёл, аялал жуулчлал, мэдээлэл, худалдааны төв", болон "Тэрэлж Монгол олле", "Хонхор тосгон Монгол олле", "Сөүлийн гудамж Монгол олле", "Урухан" брэндийн гэр мэдээллийн төв зэрэг нийт 8 байршилд тогтмол болон улирлын чанартай ажиллуулж гадаад, дотоодын нийт 5,749 хүнд, зохион байгуулсан арга хэмжээнүүдийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны цэгийг ажиллуулж 3,000 гаруй хүнд буюу нийт 8,749 гадаад, дотоодын иргэд, жуулчдад мэдээ мэдээлэл, зөвлөгөө өгч ажиллалаа.	90
2	Арга хэмжээ-1.1.2 Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийн тоог нэмэгдүүлэх	Нийслэлийн батлагдсан төсөв	Шинээр байгуулсан төвийн тоо	7	8	Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд "Чойжин" жуулчны гэр мэдээллийн төвтэй хамтран ажиллах "Санамж бичиг" байгуулан үйл ажиллагаагаа өргөжүүлэн нэмэгдүүлж, мөн Жуулчны гудамжинд байрлах "Урт цагаан" үйлчилгээний төвийн нэг давхарт жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвийг шинээр байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.	100

3	Арга хэмжээ-1.1.3 Жуулчдад зориулсан аялал жуулчлалын арга хэмжээнүүдийг зохион байгуулах	Нийслэлийн батлагдсан төсөв	Арга хэмжээ болон сонирхогч, оролцогч, жуулчдын тоо	15 70,000	16 75,000	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, үндэсний ёс заншил, өв уламжлалаар дамжуулан гадаад, дотоодын жуулчдыг татах зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран хамтран 9 арга хэмжээг зохион байгуулж, гадаад, дотоодын нийт 178,200 хүн үзэж сонирхов. ✓ "Талын Жавхаа", ✓ "Улаанбаатарын өвлийн наадам", ✓ "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль" ✓ "Бүргэдийн баяр", ✓ "Наурызын баяр", ✓ "Плэйтийм пре эвент" хөгжмийн наадам, ✓ "UB food" олон улсын хоолны фестиваль, ✓ "Бурхан багшийн дүйчин өдөр", ✓ "Талын салхи" олон улсын мото наадам	70
4	Арга хэмжээ-1.1.4 Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх	Нийслэлийн батлагдсан төсөв	Шинээр нэвтрүүлсэн бүтээгдэхүүн, үйлчилгээний тоо	1	1	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, адууны өв соёлыг таниулан сурталчлах зорилгоор "Талын жавхаа" арга хэмжээг анх удаагаа Монголын адуучдын холбоотой хамтран "Чингис Хааны Хүрээ" аялал жуулчлалын цогцолборт 2026 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгууллаа."Талын Жавхаа" адуучны тэмцээнд нийслэлийн Багануур, Багахангай, Баянзүрх, Хан-Уул, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргүүд, Архангай, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Хэнтий, Төв, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Сэлэнгэ, Увс зэрэг 13 аймгаас нийт 150 адуучин оролцож, уурга, ташуур шүүрэх, эмнэг булгиулах, морь уургалах, бугуйлдах тэмцээн зохион байгуулагдав. Арга хэмжээний үеэр адуучдын парад, урлагийн тоглолт, Монгол бүжгийн флаш моб үзүүлбэр зохион байгуулагдаж, хамгийн сайхан үндэсний дээл, хувцастай оролцогчийг шалгаруулан мөн Монгол үндэсний ахуй өвөл цагийн адуу маллах соёлтой танилцах болон морь, морин чарга уналга, гар урлалын худалдаа, үйлчилгээг зохион байгуулж, арга хэмжээг гадаад, дотоодын иргэд, жуулчид нийт 3000 гаруй хүн үзэж сонирхсон.	100

5	Арга хэмжээ-1.1.5 Үндэсний болон хотын стандартуудыг сурталчлах ажлыг зохион байгуулах	-	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	4	Үндэсний болон хотын стандартуудыг сурталчлах ажлын хүрээнд 3 арга хэмжээ зохион байгууллаа. Үүнд: ✓ Зочид буудалд ерөнхий шаардлага (MNS 4588:2008), Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага (MNS 6043:2019), Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага (MNS 5738:2007) үндэсний стандарт болон “Амралтын газар, жуулчны баазын гадна болон дотоод орчны тохижилт, зохион байгуулалтад тавигдах ерөнхий шаардлага UCS1203:2022”, “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” UCS1401B:2022”, “Хог хаягдлыг цуглуулах, ангилах, хадгалах, тээвэрлэх арга зүйн менежмент” UCS1706A:2022” хотын стандартуудыг “Улаанбаатар хотын амралтын газар, жуулчны баазуудын нэгдсэн мэдээ, мэдээлэл” цахим хуудаст байршуулж 5,000 гаруй хэрэглэгчдэд сурталчилсан. ✓ (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандарт” сэдэвт сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдөр зохион байгуулж 72 хүнийг хамруулав. ✓ Жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 05 сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан “Улаанбаатар травэл экспо 2026” олон улсын аялал аялал жуулчлалын үзэсгэлэнгийн үеэр жуулчны мэдээлэл сурталчилгааны төвийг ажиллуулж үндэсний болон хотын стандартуудын талаар 500 гаруй хүнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн.	70
6	Арга хэмжээ-1.1.6 Аялал жуулчлалын байршуулах үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд зөвлөн туслах, стандартын үзлэг зохион байгуулах	Нийслэлийн батлагдсан төсөв	Зөвлөн туслах, үзлэг зохион байгуулсан тоо	4	4	Стандартын үзлэг, зөвлөг туслах арга хэмжээг 3 байгууллага буюу Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо “Ану” зочид буудал, Баянгол дүүргийн дүүргийн 9 дүгээр хороо, Хасбаатарын 2-23 тоотод байрлах “Хан” дэн буудал, Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо “Гольдрил” ХХК-ийн “Бүрд” дэн буудлын үйл ажиллагаанд дүүргүүдийн Засаг даргын Тамгын газартай хамтран стандартын үзлэг зохион байгуулж, 2 байгууллагад албан шаардлага хүргүүлж хэрэгжилтийг хангуулан ажилласан. Улаанбаатар хотод зочин байршуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг зочид буудал, дэн буудал,	50

						жуулчны бааз, амралтын газруудад тавигдах ерөнхий шаардлага, стандартын хэрэгжилтийг хангуулах, зөвлөн туслах нэгдсэн үзлэг шалгалтыг 2026 оны II улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн боловч Монгол Улсын Засгийн газрын 2026 оны "Бизнесийн орчныг дэмжих зарим арга хэмжээний тухай" 127 дугаар тогтоолоор худалдаа, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой хууль тогтоомж, зөвшөөрлийн нөхцөл, шаардлагын талаар иргэн, хуулийн этгээдэд мэдээлэл, мэдэгдэл, зөвлөмжийг цахим хэлбэрээр хүргүүлэх, хүндрэл, дарамт учруулахгүй байх заалтын хүрээнд тухайн арга хэмжээг зохион байгуулаагүй болно.	
7	Арга хэмжээ-1.1.7 Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрутыг шинэчлэн гаргах	-	Шинээр гаргасан маршрут, чиглэлийн тоо	-	2	Байгаль, зэрлэг амьтан хамгаалах үндэсний нийгэмлэгийн "Хүрээлэн" төслийн багтай хамтран Улаанбаатар хот орчмын ногоон бүсэд явган алхалтын "Хүннү" цогцолбор-Модон цамхаг явган алхалтын зам 11.2 км, Арцат-Янгирт явган алхалтын зам 11.2 км, Скай резорт - Хүрэл тогоот - Тэмээн хад зам нь 9.1 км 3 алхалтын маршрутыг шинээр гаргаж, 2 байршилт тэмдэг тэмдэглэгээ байршуулсан.	100
8	Арга хэмжээ-1.1.8 Улаанбаатар хотын аяллын "Сити тур" төслийг үргэлжлүүлэх	Нийслэлийн батлагдсан төсөв	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Улаанбаатар хотын түүх, соёл, байгалийн нөөцөд тулгуурлан аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлэх, гадаад дотоод жуулчдын хэрэгцээнд нийцсэн хотын аяллын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор "Сити тур" төслийг хэрэгжүүлэн хот болон хот орчмын 8 удаагийн аяллаар нийт гадаад, дотоодын 400 гаруй хүнийг хотын аялалд хамруулж, 3,263,385.00 (гурван сая хоёр зуун жаран гурван мянга гурван зуун наян тав) төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	90
9	Арга хэмжээ-1.1.9 "Нэг жуулчин-нэг мод" жуулчны төгөл байгуулах төслийг үргэлжлүүлж, шинээр мод тарих ажлыг зохион байгуулах	-	Тарьсан модны тоо	320	350	"Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд Налайх дүүргийн 7 дугаар хороо "Шинэ-Налайх" цэцэрлэгт хүрээлэнгийн "Жуулчин төгөл"-д "Ибис Стайлс Улаанбаатар" зочид буудал, "Жамогранд Травел" ХХК-тай хамтран 2026 оны 05 дугаар сарын 16-ний өдөр мод тарих ажлыг зохион байгуулж 500 ширхэг хайлаас шинээр тарьж суулгав.	100
10	Арга хэмжээ-1.1.10 "Оюутан цагдаа" хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх	ГХУСАЗН СЗ	Ажлын гүйцэтгэлийн хувь	100	100	Жуулчны аюулгүй байдлыг хангах, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэднийг хэрэгцээт мэдээ, мэдээллээр хангах, эрх зүйн туслалцаа үзүүлэх зорилгоор Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал,	50

						Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, Монголын Оюутны холбоотой хамтран “Оюутан цагдаа-2026 арга хэмжээг 2026 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэхээр бэлтгэлийг хангаж байна.	
1.2. “Албан бизнес болон өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын улирлын хамаарлыг бууруулах чиглэлээр:							
11	Арга хэмжээ-1.2.1 “КОП 17” НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэн ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	“КОП-17” НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын талуудын 17 дугаар бага хурлыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд 2 дэд хорооны 12 удаагийн хуралд газрын дарга, Захиргаа санхүүгийн болон Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга нар оролцож, дэд хороодод шаардлагатай холбогдох мэдээ мэдээлэл, судалгааг тухай бүр нь гаргаж хүргүүлсэн.	50
12	Арга хэмжээ-1.2.2 XV дахь удаагийн “Азийн аялал жуулчлалын форум”-ыг хамтран зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран Азийн аялал жуулчлалын 15 дахь удаагийн олон улсын чуулганыг (ATF 2026) “Зочлох үйлчилгээ, аялал жуулчлалын азийн парадигм” сэдвийн хүрээнд 2026 оны 06 дугаар сарын 11-13-ны өдрүүдэд “Улаанбаатар” зочид буудлын хурлын танхимд зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна. Азийн аялал жуулчлалын салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, олон улсын шилдэг туршлага, шинжлэх ухааны үндэслэлтэй шийдлүүдийг хэлэлцэх чуулганд салбартаа тэргүүлэгч олон улсын эрдэмтэн судлаагчид, бизнесийн төлөөллүүд урилгаар оролцож, илтгэл хэлэлцүүлэх бөгөөд чуулганд оролцогчдын бүртгэлийг зохион байгуулж байна.	50
13	Арга хэмжээ-1.2.3 “Tourism week - аялал жуулчлалын долоо хоног 2026” арга хэмжээг хамтран зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Төр, хувийн хэвшил, салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам болон Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбоо (Mongolia Tourism Organization)-той хамтран “Tourism Week-2026” үндэсний чуулганыг 2026 оны 03 дугаар сарын 9-15-ны өдрүүдэд зохион байгууллаа. Чуулганы нээлтэд Монгол Улсын Ерөнхий сайд, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Аялал Жуулчлалын Мэргэжлийн Холбооны Ерөнхийлөгч, МХАҮТ-ын Ерөнхийлөгч болон аялал жуулчлалын салбарын 800 гаруй төлөөлөгч оролцож “Аялал жуулчлалын үндэсний чуулган”, “Аялал	100

						жуулчлалын академи", "Салбар хуралдаанууд", "Оюутан, залуучуудын өдөр-Ажлын байрын өдөрлөг", "Аялал жуулчлалын бизнес & хамтын ажиллагааны өдөр" зэрэг үндсэн бүлгүүдийн хүрээнд зохион байгуулагдаж нэгдсэн арга хэмжээнүүдэд 6000 гаруй оролцогч оролцлоо. "Tourism week-2026" үндэсний чуулган салбарын бодлого, хөгжил, тогтвортой аялал жуулчлал, дижитал шилжилт, MICE аялал жуулчлал, COP17 олон улсын хурлыг угтсан байгальд ээлтэй санаачилгууд, дижитал шийдлүүдийг нэвтрүүлэх, салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, хувийн хэвшлийн хамтын ажиллагааг өргөжүүлэх нь зэрэг сэдвүүдээр 72 илтгэгч илтгэл тавьж хэлэлцүүлсэн бөгөөд тус газрын Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн дарга С.Туул Улаанбаатар хотод 2026 онд зохион байгуулагдах эвент арга хэмжээний талаар оролцогчдод танилцууллаа.	
14	Арга хэмжээ-1.2.4 Аялал жуулчлалын салбарын бизнес эрхлэгчдийн B2B уулзалт арга хэмжээ зохион байгуулах	-	Арга хэмжээний тоо	1	1	"Tourism Week-2026" үндэсний чуулганы хүрээнд "B2B бизнес уулзалт" өдөрлөг 2026 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулагдаж уулзалтад аялал жуулчлалын салбарын 121 аж ахуйн нэгж, байгууллага оролцож, аялал жуулчлал, зочлох үйлчилгээ, агаарын тээвэр, жуулчны бааз, зочид буудал, аяллын компани зэрэг чиглэлээр нээлттэй ажлын байр, хүний нөөцийн боломжоо танилцуулж, хамтран ажиллах санал солилцох уулзалтууд боллоо.	100
15	Арга хэмжээ-1.2.5 "UB winter sale" хөнгөлөлттэй аяныг зохион байгуулах	-	Бүтээгдэхүүн үйлчилгээ болон хамрагдсан байгууллагын тоо	100/82	22/90	Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчдын улирлын хугацааг уртасгах, жуулчдад хөнгөлөлттэй үнээр үйлчлэх байгууллагуудын тоог нэмэгдүүлэх зорилгоор "UB WINTER SALE" хөнгөлөлтийн аяныг зохион байгуулж Улаанбаатар хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа соёл урлаг, аялал жуулчлал, худалдаа, үйлчилгээний 151 аж ахуйн нэгж, байгууллага 100 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээндээ 1+1 урамшуулал болон 5-70 хувь хүртэл хөнгөлөлт, урамшуулалттай үйлчилгээг иргэд, жуулчдад үзүүллээ.	100
16	Арга хэмжээ-1.2.6 Өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор жуулчдад	-	Зохион байгуулсан	5	6	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Жуулчдын урсгалыг нэмэгдүүлж, дөрвөн улирлын турш жуулчин хүлээн авах зорилтын хүрээнд хэрэгжүүлэх зарим арга	100

	зориулсан эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах		арга хэмжээний тоо			хэмжээний тухай” 191 дүгээр тогтоолын хүрээнд Улаанбаатар хотод өвлийн аялал жуулчлалын хөгжүүлэх зорилгоор төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодтой хамтран “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр” “Плэйтийм при эвент” зэрэг 6 арга хэмжээг зохион байгууллаа.	
1.3.“Худалдаа, үйлчилгээ, аялал жуулчлалын зориулалт бүхий төрөлжсөн явуулын үйлчилгээг бий болгож, жижиг дунд, бизнес эрхлэгчдийг дэмжин ажиллах чиглэлээр:							
17	Арга хэмжээ-1.3.1 Жуулчдад зориулсан худалдаа, үйлчилгээний гудамж, хэсэг бий болгох	-	Шинээр бий болсон гудамж, хэсгийн тоо	-	1	Жуулчны гудамжны тохижилтын ажил дууссантай холбогдуулан гадаад дотоод иргэд, жуулчдыг татах зорилгоор “Урт цагаан” үйлчилгээний төвтэй хамтран 2026 оны II, III улиралд худалдаа, үйлчилгээ бүхий жуулчны гудамж бий болгож Баасан, Бямба, Ням гарагуудад олон төрлийн арга хэмжээнүүдийг зохион байгуулахаар төлөвлөж, нийслэлийн удирдлагуудад танилцуулав. Мөн бизнес эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас Сүхбаатар дүүргийн 3 дугаар хороо сөүлийн гудамж хэсэгт “Соёл, аялал жуулчлалын гудамж”, “Шөнийн гудамж” бий болгох хүсэлт ирүүлснийг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албанд дэмжиж ажиллах хүсэлтийг хүргүүлсэн.	50
18	Арга хэмжээ-1.3.2 Худалдаа, үйлчилгээний гудамж, хэсэгт арга хэмжээг тогтмол зохион байгуулж, жижиг дунд, бизнес эрхлэгчдийг хамруулан дэмжлэг үзүүлэх	-	Жижиг, дунд бизнес эрхлэгчдийн тоо	-	50	Гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Плэйтийм пре эвент” хөгжмийн наадам, “UB food” олон улсын хоолны фестиваль “Бурхан багшийн дүйчин өдөр”, “Талын салхи” олон улсын мото наадам зэрэг 9 арга хэмжээний үеэр 223 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан.	100
1.4.“Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгаанд дэвшилтэд технологийг нэвтрүүлж, контент бэлтгэн, гадаад дотоодод түгээн сурталчилах чиглэлээр:							
19	Арга хэмжээ-1.4.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын сурталчилгааны материал (танилцуулга,	Нийслэлийн төсөв	Сурталчилгааны материалын тоо	27,450	30,000	Нийслэл Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, жуулчдыг хэрэгцээт мэдээ мэдээллээр хангах, олон улсын үзэсгэлэн, арга хэмжээний үеэр ашиглах Улаанбаатар сэтгүүл 18000 ширэг (Англи, Герман, Япон, Солонгос, Орос, Хятад хэл дээр), Улаанбаатар	100

	сэтгүүл, газрын зураг, хөтөч ном) шинэчлэх					хотын хөтөч ном (Guide book), жуулчдад зориулсан Улаанбаатар хотын газрын зураг 10000 ширхэг (City map), "Улаанбаатар 360" явган алхалтын хөтөч ном 2000 ширхэг нийт 9 төрлийн 30,000 ширхэг сурталчилгааны материалыг хэвлүүлж Монгол Улсад суугаа гадаад улсуудын Элчин сайдын яамд, консулын газрууд, аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, Жуулчны мэдээлэл, сурталчилгааны төвүүд болон гадаад, дотоодод зохион байгуулагдсан олон улсын үзэсгэлэн, уулзалт, хурал, зөвлөгөөн, эвент арга хэмжээнүүдэд 6000 гаруй тараах материал олгож Улаанбаатар хотыг сурталчлан ажиллаж байна.	
20	Арга хэмжээ-1.4.2 Жуулчдад зориулсан цахим сайт, гар утасны аппликейшны үйл ажиллагааг хөгжүүлэн тогтмолжуулах	Нийслэлийн төсөв	Ашиглалтад оруулсан аппликейшны тоо	-	1	Жуулчдад зориулсан гар утасны аппликейшн гадаад, дотоодын жуулчдад зориулсан www.visit-ulaanbaatar.com веб хуудас болон Visit Ulaanbaatar аппликейшнд голлох зах зээлийн орнууд буюу (япон, солонгос, хятад, орос) хэлний сонголтыг цэс хэсэгт нэмж хөгжүүлэлтийг хийж байна. Мөн хөгжүүлэлтээр веб хуудасны хэрэглэгчийн интерфэйс (UI/UX) болон арын систем (Backend)-д техникийн шинэчлэл хийж, 4 улсын хэлний сонголтын модулийг шинээр суулгасан. Хэлний цэсийг веб хуудасны үндсэн нүүрний баруун дээд хэсэгт цэс (Dropdown menu) хэлбэрээр байршууллаа.	100
21	Арга хэмжээ-1.4.3 Улаанбаатар хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан онцлох арга хэмжээг сурталчлах	Нийслэлийн төсөв	Эй Ар, Ви Ар технологиор бүтээсэн контентын тоо	2	3	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээнд орчин үеийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж хотын аялал жуулчлалын маршрут, зорин очих газрууд, жуулчдад зориулсан соёл, аялал жуулчлалын арга хэмжээг сурталчлах ажлын хүрээнд мета куэст 3S төрлийн 11 ширхэг Ви Ар (VR) төхөөрөмжөөр 36 бүтээгдэхүүн үйлчилгээнд VR 360 зураг авалт хийж, Web AR 3D модель контент хийсэн. Нэмэлтээр Улаанбаатар хотын 20 гаруй бүтээгдэхүүн, үйлчилгээний Ви Ар зураг авалтыг нэмж хийх, веб хуудаснаас үзэх боломжтой болгохоор программ шинэчлэлтийн ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.	50
22	Арга хэмжээ-1.4.4 Улаанбаатар хотын сурталчилгааны контент	Нийслэлийн төсөв	Шинээр хийсэн контентын тоо	-	2	"Талын Жавхаа", "Улаанбаатарын өвлийн наадам", "Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль", "Бүргэдийн баяр", "Наурызын баяр" "UB food" олон	70

	бүтээж гадаад дотоодод түгээн сурталчлах					улсын хоолны фестиваль "Бурхан багшийн дүйчин өдөр", "Талын салхи" олон улсын мото наадам зэрэг 9 арга хэмжээнүүдтэй холбоотой зэрэг контент 1 нэвтрүүлэг, 2 видео танилцуулга, 28 сурталчилгааны рийл хийж байгууллагын www.tourism.ub.gov.mn www.visitulaanbaatar.net цахим хуудас болон газрын facebook, instagram, youtube сувгуудаар цахим сүлжээнд байршуулж олон нийтийн сүлжээгээр сурталчилсан.	
23	Арга хэмжээ-1.4.5 Жуулчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр контентыг хийж, жуулчид ихээр зорчдог байршлуудаар сурталчлах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	Жуулчны аюулгүй байдлыг хангах чиглэлээр видео контент шинээр хийж голлох зах зээлийн орнуудын хэл дээр (англи, хятад, орос, солонгос) орчуулгыг бүрэн хийж дуусгаж, дууны засварын ажлыг гүйцэтгэж байна. Энэхүү видео контентуудыг 2026 оны 06 дугаар сараас эхлэн газрын цахим сувгууд байршуулж, мөн Нийслэлийн Цагдаагийн удирдах газар, томоохон худалдааны төвүүд холбогдох аялал жуулчлалын байгууллагуудад хүргүүлж сурталчлах ажлыг зохион байгуулахаар ажиллаж байна.	50
1.5. "Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах чиглэлээр гадаад хамтын ажиллагааг эрчимжүүлэх чиглэлээр:							
24	Арга хэмжээ-1.5.1 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах	Нийслэлийн төсөв	Оролцсон үзэсгэлэн, арга хэмжээний тоо	9	10	"Монголд зочлох жил"-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо, тур оператор компаниудтай хамтран олон улсын 8 үзэсгэлэн, арга хэмжээнд оролцож "Улаанбаатар хотын сэтгүүл", "Guidebook" 2 төрлийн 3000 сурталчилгааны материал тарааж, мета куэст 3S төрлийн 2 ширхэг Ви Ар /VR/ төхөөрөмжөөр бүтээгдэхүүн үйлчилгээгээ сурталчилсан. Үүнд: ✓ ХБНГУ-ын Берлин хотноо 2026 оны 03 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB Berlin" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн, ✓ БНСУ-ын Бусан хотноо 2026 оны 05 сарын 11-14-ний өдрүүдэд Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллага (ТРО)-аас зохион байгуулсан "ТРО Capacity Building Program-2026" олон улсын арга хэмжээ,	80

						✓ БНХАУ-ын Тианжин хотноо 2026 оны 05 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулсан "Улаанбаатар -Тианжин" хот хоорондын шууд нислэгийн нээлтийн арга хэмжээ ✓ БНХАУ-ын Шанхай хотноо 2026 оны 05 дугаар сарын 26-28-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "ITB China Shanghai" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн ✓ Улаанбаатар хотноо 2026 оны 05 дугаар сарын 29-31-ний өдрүүдэд зохион байгуулагдсан "Улаанбаатар травел експо 2026" дотоодын аялал жуулчлалын үзэсгэлэнд 56 ААН ✓ БНСУ-ын Сөүл хотноо 2026 оны 06 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулагдсан "SITF 2026" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн ✓ БНХАУ-ын Бээжин хотноо 2026 оны 06 дугаар сарын 01-04-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Дэлхийн Аялал Жуулчлалын Хотуудын Холбоо (WTCTF)-ны "Beijing Fragrant Hills Tourism Summit 2026" өнөдөр хэмжээний чуулга уулзалт ✓ Хонгконг хотноо 2026 оны 06 дугаар сарын 11-14-ний өдрүүдэд зохион байгуулагдах "ITE Hongkong" олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн	
25	Арга хэмжээ-1.5.2 Найрамдалт харилцаат хотуудад Улаанбаатар хотыг сурталчлах соёл урлаг, аялал жуулчлалын арга хэмжээ зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	1	1	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах зорилгоор аялал жуулчлалын мэргэжлийн холбоод, тур оператор компаниудтай хамтран "Улаанбаатар хотын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг 2026 оны 09 сард зохион байгуулахаар төлөвлөж, бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.	-
26	Арга хэмжээ-1.5.3 Улаанбаатар хотод Найрамдалт харилцаат хотуудын аялал жуулчлал, соёл, урлагийн арга хэмжээ зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	4	2	Монгол Улсад суугаа Бүгд найрамдах Солонгос Улсын элчин сайдын яамтай хамтран "Солонгосын соёл, аялал жуулчлалын өдрүүд" арга хэмжээг 2026 оны 09 дүгээр сарын 05-06-ны өдрүүдэд жанжин Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна. Тайлагнах хугацаа болоогүй.	-
27	Арга хэмжээ-1.5.4 Олон улсын байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, Улаанбаатар	-	Хамтран ажилласан байгууллагын тоо	2	3	Олон улсын байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, байгууллагын үйл ажиллагаанд олон улсын туршлага нэвтрүүлэх, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад улсад	100

	хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг олон улсад сурталчлах					зорилгоор Япон Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч байгууллага болох "ЖАЙКА" (Japan International Cooperation Agency), Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллага (Tourism Promotion Organization for Global Cities), Дэлхийн Аялал Жуулчлалын Хотуудын Холбоо (WTCF), БНСУ-ын Жэжү Олле нийгэмлэгтэй хамтран ажиллаж, үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна.	
1.6. Гадаад, дотоод хэвлэл мэдээллийн байгууллагууд, дэлхийд алдартай аялагч нөлөөлөгчдийг урин Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах чиглэлээр:							
28	Арга хэмжээ-1.6.1 Олон улсад алдартай аялагч нартай хамтран ажиллаж, Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг сурталчлах	Нийслэлийн төсөв	Сурталчилсан сурталчилгааны тоо	5	5	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг цахим сүлжээгээр олон нийтэд сурталчлах ажлын хүрээнд 2026 оны 03 дугаар сарын 07, 08-ны өдрүүдэд Чингис хааны хүрээ аялал жуулчлалын цогцолборт зохион байгуулсан "Бүргэдийн баяр" арга хэмжээг инфлюенср Т.Саруултерс (Tuugu Saruultugs)-өөр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсан "Playtime" олон улсын хөгжмийн наадмын "Pre event" арга хэмжээг М.Ганбаяр инфлюенсер (Gremix)-ээр, жанжин Д.Сүхбаатарын талбайд 2026 оны 04 дүгээр сарын 17-26-ны өдрүүдэд зохион байгуулсан "УБ фүүд фестиваль" арга хэмжээг олны танил аялагч, судлаач Ц.Ган-өлзий (аяллын тойрог), Н.Энхбаяр (хоолондоо), Ч.Машнууцсүх (Мангас машаа-Meat-lover Monsters of Mongolia), мастер тогооч Ц.Мэнджаргал (Miko Miko) зэрэг нийт 7 нөлөөлөгчөөр дамжуулан 1 нэвтүүлэг, 8 удаагийн лайв, 31 удаагийн рийлс, 21 удаагийн пост мэдээлэл хийлгүүлж цахим орчинд түгээж, давхардсан тоогоор нийт 5,150,281 хүнд хүргэсэн байна.	100
29	Арга хэмжээ-1.6.2 Олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран олон нийтийн цахим сүлжээгээр Улаанбаатар хотын маркетинг сурталчилгааг хийх	Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	-	100	Улаанбаатар хотын аялал жуулчлалын онцлох бүтээгдэхүүн үйлчилгээг олон улсад сурталчлах зорилгоор Япон Улсын NHK телевизийн "Great nature" нэвтрүүлгийн багтай хамтран ажиллаж, нэвтрүүлгийн агуулгад нийцүүлэн зураг авалтын ажлыг хийж дуусган 2026 оны 07 дугаар сард Япон Улсын NHK, Монгол Улсын Монголын үндэсний радио, телевиз, Сүлд ТВ болон Тэнгэр ТВ-үүдээр түгээхээр ажиллаж байна. БНХАУ-ын ӨМӨЗО-ны улсын хорооны Монгол дахь төлөөлөгчийн газраас бэлтгэн хүргэдэг "Сайн байна уу	50

						дундад орон" нэвтрүүлгийн багтай хамтран "Сайн байна уу Монгол орон, Сайн байна уу Улаанбаатар хот" сэдвийн хүрээнд Улаанбаатар хотын аялал жуулчлалын онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээг БНХАУ болон ӨМӨЗО-ны иргэдэд 5 цуврал нэвтрүүлэг болгон хүргэхээр төлөвлөж ажиллаж байна.	
30	Арга хэмжээ-1.6.3 Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах фам турыг хот болон хот орчимд зохион байгуулах	Нийслэлийн төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь	100	100	Улаанбаатар хотыг олон улсад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор олон улсын аялал жуулчлалын салбарын шилдэг байгууллагуудын төлөөллийг оролцуулан Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн үйлчилгээг сурталчлах фам турыг 2026 III улиралд зохион байгуулахаар бэлтгэлийг ханган ажиллаж байна.	50
31	Арга хэмжээ-1.6.4 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, арга хэмжээг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	Нийслэлийн төсөв	Хамтран ажилласан байгууллагын тоо	11	20	Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, жуулчдад зориулан зохион байгуулсан үзэсгэлэн, эвент арга хэмжээнүүдийн талаар MYONPTV, Ийгл ТВ, SBN, TV9 гэх мэт 7 телевиз, Өнөөдөр, Өдрийн сонин, Зууны мэдээ гэх мэт 8 сонин, Zarig.mn, Gogo.mn, News.mn, Zugii.mn зэрэг веб сайтууд, нийт 25 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж, 5 эвент, арга хэмжээний талаар 50 гаруй цуврал мэдээ мэдээлэл нийтлүүлж үйл ажиллагаагаа сурталчлан ажилласан.	100
32	Арга хэмжээ-1.6.5 Улаанбаатар хотын аялал жуулчлалыг иргэд олон нийт, жуулчдад түгээн сурталчлах	Нийслэлийн төсөв	Хандалтын тоо	2,000,000	3,000,000	Байгууллагын цахим хуудас www.tourism.ub.gov.mn болон газрын facebook, instagram, youtube цахим сүлжээнд давхардсан тоогоор 464 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж 3,212,890 хүнд хандалт авч үйл ажиллагаагаа олон нийтэд нээлттэй хүргэн ажилласан. Тухайлбал: ✓ www.tourism.ub.gov.mn цахим хуудсанд 62 мэдээ, мэдээлэл оруулж, хандалтын тоо 9,800 ✓ www.visit-ulaanbaatar.com цахим хуудсанд 34 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж хандалтын тоо 103,406 ✓ https://www.facebook.com/UlaanbaatarTourism цахим хуудсанд 329 мэдээ мэдээлэл, фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 39,335 хандалтын тоо 2,606,908	100

						✓ https://www.instagram.com/visit.ulaanbaatar/ цахим хуудсанд 27 фото зураг, дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 432, хандалтын тоо 486,036 ✓ https://www.youtube.com/channel/UCjnuixwnzpDZzieEnhXfPFA цахим хуудсанд 12 дүрс бичлэг оруулж дагагчдын тоо 525, хандалтын тоо 6,740 байна.	
33	Арга хэмжээ-1.6.6 Улаанбаатар хотын аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг гадаад улсад цахим сүлжээгээр сурталчлах	Нийслэлийн төсөв	Сурталчилсан тоо	-	1	Дэлхийн хотуудын аялал жуулчлалыг дэмжих байгууллага (Tourism Promotion Organization for Global Cities)-ын ёсны цахим хуудас болон БНСУ-ын Бусан хотын захиргааны байгууллагын сурталчилгааны дэлгэц /Busan city hall/, Busan Yongdusan Media Park-ын сурталчилгааны дэлгэцүүдээр Улаанбаатар хотын сурталчилгааны видеог байршуулж үйл ажиллагаагаа сурталчилж байна. (133) TPO Member Promotional Video 2026 – YouTube	100
Хоёр.Хуулиар олгосон нийтлэг чиг үүрэг							
2.1.Хөгжлийн бодлого болон захирамжлалын баримт бичгүүдийн хэрэгжилтийн чиглэлээр:							
34	Арга хэмжээ-2.1.1 Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд санал боловсруулж хүргүүлэх, байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг хангаж тогтоосон хугацаанд тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Монгол Улсын 2027 оны хөгжлийн төлөвлөгөө, төсвийн төсөлд тусгах саналыг боловсруулж Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. Улс, нийслэлийн урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан байгууллагын чиг үүрэгт хамаарах зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж 2026 оны эхний хагас жилийн байдлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилт 24 арга хэмжээний хэрэгжилт 75.0 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт 18 арга хэмжээний хэрэгжилт 78,0 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж тогтоосон хугацаанд тайлагнаж ажилласан.	90
35	Арга хэмжээ-2.1.2 Хууль тогтоомж, тогтоол шийдвэр болон Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, Засаг даргын зөвлөлийн хуралдааны	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	90-100	90-100	Байгууллагын чиг үүрэгт хамаарах Монгол Улсын хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 6 заалт, Нийслэлийн Засаг даргын 16 захирамжийг байгууллагын хяналтад бүртгэж, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт (түүвэр) 87,0 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 97,5 хувийн гүйцэтгэлтэй	90

	тэмдэглэлийн холбогдох заалтыг хяналтад бүртгэж, хэрэгжилтийг ханган тогтоосон хугацаанд тайлагнах					хэрэгжиж тайлан мэдээг тухай бүр тогтоосон хугацаанд тайлагнасан.	
36	Арга хэмжээ-2.1.3 Засгийн газрын гишүүн, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай төрийн зарим чиг үүргийг 2026 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээ туссан арга хэмжээний хэрэгжилтийг хангаж, заасан хугацаанд тайлагнах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчтай төрийн зарим чиг үүргийг 2026 онд төлөөлөн гүйцэтгүүлэх гэрээний хавсралтаар баталсан аялал жуулчлалын 16 арга хэмжээний биелэлт 88,2 хувийн үзүүлэлттэй хэрэгжиж тайлан мэдээг тогтоосон хугацаанд тайлагнасан.	100
37	Арга хэмжээ-2.1.4 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилт, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын үйл ажиллагаа, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх	-	Шинжилгээ, үнэлгээ хийсэн баримт бичгийн тоо	10	12	Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Хяналт-шинжилгээ хийх журам", "Үнэлгээ хийх журам", "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын хүрээнд бодлогын баримт бичгүүд, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан зэрэг 5 баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. Үүнд: Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 6 зорилт 24 арга хэмжээний хэрэгжилт 75.0 хувь, Нийслэлийн Хөгжлийн 2026 оны төлөвлөгөөнд тусгагдсан 1 зорилт 18 арга хэмжээний хэрэгжилт 78,0 хувь, байгууллагын 2026 оны гүйцэтгэлийн тайлан 80.0 хувь, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт 87,0 хувь, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт 97,5 хувийн үзүүлэлттэй дүгнэгдсэн.	70
2.2. Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, авилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр:							
38	Арга хэмжээ-2.2.1 "Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх үйл	Байгууллагын батлагдсан төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	95.0	100	1. Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх байгууллагын албан хаагчдын сургалтын төлөвлөгөөг 2026 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталж, нийт 24 удаагийн сургалтад давхардсан тоогоор 124 албан	90

	ажиллагааны төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжилтийг ханган ажиллах					хаагч, 2 удаагийн хэлэлцүүлэг, зөвлөгөөн, хөтөлбөрт давхардсан тоогоор 15 албан хаагч хамруулж, гадаад улс оронд зохион байгуулагдсан үзэсгэлэн, арга хэмжээнд 5 албан хаагч оролцож туршлага судалсан. 2. “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах төлөвлөгөө”-г 2026 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр баталж, төлөвлөгөөний дагуу дараах ажлуудыг зохион байгууллаа. Үүнд: ✓ Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын дагуу 2 албан хаагчид ээлжийн амралтын олговор, давхардсан тоогоор 68 албан хаагчид илүү цаг ажилласан нэмэгдэл хөлс олгож, хүний нөөцийн нэгдсэн систем https://hrm.csc.gov.mn/ системд албан хаагчдын бүрэлдэхүүн хөдөлгөөний мэдээллийг тогтмол шинэчлэн ажиллаж байна. ✓ Төрийн захиргааны албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулах саналыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн Ахлах түшмэл-Гутгаар зэрэг 1 албан хаагч, Дэс түшмэл-Дэд зэрэг 2 албан хаагч, Дэс түшмэл-Гутгаар зэрэг 2 албан хаагч буюу нийт 5 албан хаагчдад төрийн захиргааны албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгуулсан. ✓ Албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг 2 удаа буюу Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран 16 албан хаагчийг, “Сөүл сениорс Монголиа” ХХК-ийн Сөүл эмнэлэгтэй хамтран 3 албан хаагчийг эрүүл мэндийн эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт хамрууллаа. ✓ Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан албан хаагчдын 29 хүүхдэд хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг зохион байгууллаа. ✓ Засгийн газрын 2026 оны 119 дүгээр тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/564 дүгээр захирамжийн хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны “Хуваарь	
--	---	--	--	--	--	--	--

						батлах тухай” А/17 дугаар тушаалаар албан хаагчдыг долоо хоногийн ажлын нэг өдөр цахимаар, ажил эхлэх цагийг 07.00-08.30, тарах цагийг 16.00-17.30 цагт шилжүүлэн ажиллаж байна.	
39	Арга хэмжээ-2.2.2 Хүний нөөцийн ил тод байдлыг ханган сул орон тоог нөхөх ажлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Төрийн жинхэнэ албан хаагчийн сул орон тооны зарыг нийтэд ил тод мэдээлж, Бодлогын хэрэгжилтийн хэлтсийн Гадаад хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтний сул орон тооны захиалгыг Төрийн албаны зөвлөлийн Нийслэл дэх салбар зөвлөлд хүргүүлэн тусгай шалгалтыг зохион байгуулж, 1 албан хаагчийг албан тушаалд томилсон.	100
40	Арга хэмжээ-2.2.3 Жендерийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Монгол Улсын Засгийн газар, Жендерийн үндэсний хороотой хамтран Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр, Монгол цэргийн өдрийг тохиолдуулан зохион байгуулсан “Харилцан хүндэтгээ” нэг сарын аяны хүрээнд 2 төрлийн баннер, бичлэгийг байгууллагынхаа цахим хуудсаар дамжуулан 4,686 хүнд хүргэсэн. Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох зүйл, заалтын дагуу 16 албан хаагчид хүүхдээ хичээл, сургуульд нь хүргэж өгөх ажлын цагийн зохицуулалт хийж, мөн нийтээр тэмдэглэх баярын өдрүүдэд болон тэмдэглэлт өдрүүд, амралтын өдрүүдэд ажилласан нийт 68 (давхардсан тоогоор) албан хаагчдад илүү цаг ажилласан нэмэгдэл хөлсийг тооцон олгосон.	90
41	Арга хэмжээ-2.2.4 Авлига, албан тушаалын гэмт хэрэг, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	90	100	Байгууллагын “Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2026 оны 03 дугаар сарын 31-ний өдөр батлан батлан хэрэгжүүлж, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн дагуу 8 албан хаагч хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгээ хуулийн хугацаанд тайлагнасан. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг чиглэлээр Авлигатай тэмцэх газраас зохион байгуулсан 4 удаагийн сургалтад 11 албан хаагч хамрагдсан.	90

42	Арга хэмжээ-2.2.5 Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагааны төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	90	90	Байгууллагын Ёс зүйн дэд хорооноос 2026 онд хэрэгжүүлэх 11 арга хэмжээний төлөвлөгөөг батлан байгууллагын Ёс зүй дэд хороо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Төрийн албан хаагчийн ёс зүй, эрх зүй" сэдвээр сургалт зохион байгуулж, "ЁС ЗҮЙ- Шинэчлэл- ШИНЭ СОЁЛ" уриалгыг гаргаж, ёс зүйн самбарыг тогтмол ажиллуулж, зурагт хуудас, уриалгыг байршуулсан.	90
2.3. Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны чиглэлээр:							
43	Арга хэмжээ-2.3.1 Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж, өр авлага үүсгэхгүй ажиллаж төсвийн гүйцэтгэлийг хуулийн хугацаанд тайлагнах	Байгууллагын батлагдсан төсөв	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	100	Санхүүгийн үйл ажиллагаанд төсөв, санхүүгийн сахилга батыг чанд мөрдөж, төсвийн зардлыг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулж санхүүгийн тайлан мэдээг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, шинээр авлага, өр төлбөр үүсгээгүй ажилласан. Нийт батлагдсан төсвийг зардлын ангилал тус бүрээр нь зарцуулсан. Үүнд: ✓ Үндсэн цалин 283,440,606.82 төгрөг ✓ Нийгмийн даатгалд 34,828,851.43 төгрөг ✓ Хангамж, бараа материалын зардал 11,246,415.00 төгрөг ✓ Эд хогшил, урсгал засварын зардал 500,000.00 төгрөг ✓ Мэргэжлийн үйлчилгээний төлбөр 16,770,955.00 төгрөг	90
44	Арга хэмжээ-2.3.2 Байгууллагын туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих төсвийн орлогын төлөвлөгөөг ханган биелүүлэх	-	Орлого бүрдүүлэлт	36.0	30.0	Байгууллагын 2026 оны төсөвт туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 30,000,000 (гучин сая) төгрөгийн орлогыг төвлөрүүлэхээр батлагдсан. "Сити тур" төслийн хүрээнд орлогын төлөвлөгөөний биелэлтийг төсвийн хуваарийн дагуу 2026 оны 05 дугаар сараас эхлэн хэрэгжүүлэн 3,263,385.00 төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн.	30
45	Арга хэмжээ-2.3.3 Байгууллагын өмч, хөрөнгийг эзэмших, ашиглах, захиран зарцуулах аливаа гэрээний биелэлт, гүйцэтгэлийг ханган ажиллах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн Өмчийн харилцааны газраас өгсөн чиглэлийн хүрээнд "Бэлхийн амны Хүннүгийн язгууртны цогцолбор"-ын тохижилтын нийт 489,361,441.00 төгрөгийн өртөг бүхий хөрөнгийг Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2026 оны А/01 тушаалаар бүртгэж авсан. Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын шалгалтаар өгсөн зөвлөмжийн дагуу ашиглалтын хугацаа дууссан үндсэн хөрөнгүүдийг Өмч хамгаалах	90

						байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж дахин үнэлүүлэх хөрөнгийн жагсаалтыг гарган 2026 оны 04 дүгээр сарын 07-ны өдөр Нийслэлийн Өмчийн харилцааны газарт албан бичгээр хүргүүлсэн.	
46	Арга хэмжээ-2.3.4 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, төсвийн ил тод байдлыг ханган цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийг үнэн зөв тогтоосон хугацаанд байршуулах	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Шилэн дансны тухай хууль болон холбогдох дүрэм, журмын хэрэгжилтийг хангаж www.info.shilendans.gov.mn цахим санд байгууллагын жилийн төсөв, гүйцэтгэл, төсвийн хэмнэлт, аудитын зөвлөмжийн тайлан, санхүүгийн тайланг тогтоосон хугацаанд байршуулан тайлагнаж, үндсэн болон нэмэлтээр санхүүжсэн үйл ажиллагааны чиглэлээр нийт 29 төрлийн 116 мэдээллийг цаг хугацаанд нь тайлагнасан.	90
2.4. Бусад нийтлэг чиг үүргийн чиглэлээр:							
47	Арга хэмжээ-2.4.1 Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөнөөс өгсөн үүрэг даалгавар, бусад холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Нийслэлийн удирдах ажилтнуудын 13 удаагийн шуурхай зөвлөгөөнөөс байгууллагын чиг үүрэгт хамаарах 18 үүрэг даалгаврын биелэлтийг заалт тус бүрээр бүрэн ханган хэрэгжилтийг тухай бүр хугацаанд нь тайлагнаж, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас ирүүлсэн хуулийн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний санал, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, тайлан мэдээ, мэдээлэл, судалгааг цаг хугацаанд нь хүргүүлж, нийслэлийн удирдлагуудаас холбогдох чиглэлээр өгсөн үүрэг даалгаврыг тухай бүр хэрэгжүүлэн тайлагнан ажилласан.	100
48	Арга хэмжээ-2.4.2 Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтох, суурь түвшинг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	-	90	Хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс байгууллагын хариуцах индексийн үзүүлэлтийг тогтоон индексийн үзүүлэлтийн суурь түвшинг сайжруулах үйл ажиллагааны 2 бүлгийн 23 арга хэмжээг хэрэгжүүлэх төлөвлөгөө баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	70
49	Арга хэмжээ-2.4.3 Хариуцсан чиг үүргийн хүрээнд шинжилгээ хийж, засаглалын тогтолцоог оновчтой болгох замаар үр ашгийг нэмэгдүүлэх	-	Хэрэгжилт, хувиар	100	100	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2025 оны А/123 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн хүрээнд Нийслэлийн Аялал жуулчлалын газрын даргын 2025 оны А/49 дүгээр тушаалаар нийтлэг чиг үүрэг хэрэгжүүлдэг нэгжид чиг үүргийн шинжилгээ хийхэд шаардлагатай мэдээлэл бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх	100

	ажлыг хамтран зохион байгуулах					үүрэг бүхий салбар ажлын хэсэг байгуулж, байгууллагын 18 албан хаагчийн албан тушаалд чиг үүргийн шинжилгээний талаарх судалгаа, мэдээллийг бүрэн гүйцэтгэж холбогдох ажлын хэсгүүдэд хүргүүлсэн.	
50	Арга хэмжээ-2.4.4 MNS ISO 9001:2016-чанарын менежментийн тогтолцооны стандартын баталгаажуулалтыг хангах төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	90	90-100	"ISO 9001:2015 стандарт"-ын дагуу чанарын менежментийн тогтолцоонд хөндлөнгийн магадлах аудит хийх, баталгаажуулалтын гэрчилгээ сунгах гэрээг "Глобал куалити" ХХК-тай байгуулж, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна	50
51	Арга хэмжээ-2.4.5 Хариуцсан чиг үүргийн хүрээний албан ёсны болон захиргааны статистикийн мэдээллийг боловсруулах, тайлагнах тогтолцоог хөгжүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	-	Хэрэгжилт, хувиар	90	90	"Аялал жуулчлалын мэргэжлийн холбоо" нийтийн эрх зүйн этгээдтэй хамтран Монгол Улсад ирсэн жуулчдын статистик тоон мэдээллийн МУ-ын хилээр нэвтэрсэн гадаадын иргэдийн тоонд үндэслэн өдөр, сар, жилээр, улсаар нь ангилан гаргаж олон нийтэд хүргэн ажиллаж байна.	70
52	Арга хэмжээ-2.4.6 Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөг хэрэгжилтийг хангаж ажиллаж, тогтоосон хугацаанд тайлагнах	-	Стратеги төлөвлөгөөний хэрэгжилт, хувиар	-	90	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөний 13 зорилтын 35 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Жилийн эцсийн байдлаар тайлагнана.	-
53	Арга хэмжээ-2.4.7 Хяналт, мониторингийн тогтолцоог сайжруулж, олон улсын үнэлгээний систем нэвтрүүлэх ажлыг хамтран зохион байгуулах	-	Хэрэгжилт, хувиар	90	90	Байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо (KPI)-г сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "KPI тогтолцоо"-ны нэгдсэн сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Олон улсын үнэлгээний системийг нэвтрүүлэхтэй холбоотой нэгдсэн чиглэл, арга зүй, хамтран ажиллах асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй тул бодит хэрэгжилтийн ажил эхлээгүй байна. Цаашид холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж, шаардлагатай нөхцөл бүрдсэнээр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	50
54	Арга хэмжээ-2.4.8 Тогтвортой хөгжилд тулгуурласан засаглалын шинэчлэлийн бодлогын хүрээнд стратегийн	-	Хэрэгжилт, хувиар	-	90	Байгууллагын хяналт шинжилгээ үнэлгээний тогтолцоо (KPI)-г сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан "KPI тогтолцоо"-ны нэгдсэн сургалтад 1 албан хаагч хамрагдсан. Олон улсын үнэлгээний системийг нэвтрүүлэхтэй холбоотой нэгдсэн чиглэл,	50

	төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээний KPI аргачлалыг нэвтрүүлэх					арга зүй, хамтран ажиллах асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй тул бодит хэрэгжилтийн ажил эхлээгүй байна.	
55	Арга хэмжээ-2.4.9 Газрын алсын хараа, үнэт зүйл, зорилгыг ажилчдад ойлгомжтой байдлаар түгээн, дотоод сургалт, хэлэлцүүлгээр дамжуулан хамтран тодорхойлох		Хэрэгжилт, хувиар	-	90	Байгууллагын 2025-2028 оны стратеги төлөвлөгөөнд алсын хараа, эрхэм зориг, стратеги зорилтууд батлагдаж стратеги төлөвлөгөөг танилцуулах дотоод сургалтыг 2026 оны 02 дугаар сарын 25-ны өдөр зохион байгууллаа.	90
56	Арга хэмжээ-2.4.10 Байгууллагын шаардлагатай журмуудыг боловсруулах, хэрэгжилтийг хангах, байгууллагын дүрэм, журмын хэрэгжилтэд хяналт тавьж, дүн шинжилгээ хийх		Хэрэгжилт, хувиар	-	90	Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын хэрэгжилтийн байдалд судалгаа хийж, шинэчлэн боловсруулах шаардлагатай журмуудын жагсаалтыг гарган газрын даргын 2025 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн А/45 дугаар тушаалаар хөдөлмөрийн дотоод журмыг шинэчилсэн. “Хөдөлмөрийн дотоод журам”-ын хэрэгжилтэд дүн шинжилгээг 2026 оны IV улиралд зохион байгуулахаар төлөвлөсөн.	50
57	Арга хэмжээ-2.4.11 Байгууллагын соёлын үнэлгээ, дотоод сэтгэл ханамжийн судалгааг хийх, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах		Хэрэгжилт, хувиар	-	90	Байгууллагын соёл болон ажлын байрын сэтгэл ханамжийг үнэлэх 20 асуулга бүхий судалгааг нийт албан хаагчдаас авч, дүнг нэгтгээд байна.	70

Гурав: Төрийн үйлчилгээ

3.1.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, үр дүнг дээшлүүлэх чиглэлээр:

58	Арга хэмжээ-3.1.1 “Онлайн бизнес төв” нэгдсэн мэдээллийн системийн “Үйлчилгээ эрхлэх бүртгэл” цэсэд аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр	-	Шийдвэрлэлтийн хувь	90	100	https://license.e-business.mn/ зөвшөөрлийн цахим системд аялал жуулчлалын байр сууцны үйлчилгээ эрхлэгч иргэн, хуулийн этгээдээс зочид буудал, дэн буудал, амралтын газар, жуулчны баазын үйлчилгээ эрхлэхээр 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 137 хүсэлт гаргагчаас зөвшөөрсөн 83, буцаагдсан 45, татгалзсан 3, хянагдаж байгаа 3, хариуцсан дүүрэгт шилжүүлсэн 3, төлөвтэй байна.	90
----	--	---	---------------------	----	-----	---	----

	бүртгэлийг тухай бүр хянан шийдвэрлэх						
59	Арга хэмжээ-3.1.2 Албан хэрэг хөтлөлтийг холбогдох хууль, дүрэм, журам, стандартын дагуу зохион бүрдүүлэн хөтлөх, ирсэн бичгийг цаг хугацаанд нь шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хувиар	99	100	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны эхний хагас жилийн байдлаар төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуй нэгжүүдээс ирүүлсэн хариутай 57 албан бичиг, хариугүй 151 албан бичиг нийт 208 албан бичгийг бүртгэж, 214 албан бичгийг албан хэрэг хөтлөлтийн заавар, журам, стандартын дагуу боловсруулан илгээсэн. Ирүүлсэн 202 албан бичгийг бүрэн шийдвэрлэж 6 албан бичиг судлагдаж байна. Албан бичгийн шийдвэрлэлт 100 хувийн үзүүлэлттэй байна.	100
60	Арга хэмжээ-3.1.3 “Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу хэвлэмэл хуудсыг захиалах, албан хэргийг крилл болон үндэсний хос бичгээр хөтлөх	-	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	-	100	“Монгол бичгээр үйлдэх баримт бичгийн хэвлэмэл хуудас түүний бүрдэлд тавих үндсэн шаардлага” MNS6395:2022 стандартын дагуу Нийслэлийн Аялал жуулчлалын газрын 57 тушаал, явуулсан 214 албан бичгийг хос бичгээр хөтлөсөн.	100
61	Арга хэмжээ-3.1.4 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл хүсэлт, санал гомдлыг түргэн шуурхай хуулийн хугацаанд шийдвэрлэх	-	Шийдвэрлэлтийн хугацаагаар	5 хоног	5 хоног	Нийслэлийн Аялал жуулчлалын газарт 2026 оны эхний хагас жилийн байдлаар нийт 9 өргөдөл гомдол, санал хүсэлт ирүүлснийг 100% эцэслэн шийдвэрлэж хуулийн хугацаанд хариу өгч ажилласан. Нийт өргөдөл, гомдлоос албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбоотой гомдол болон саналын шинжтэй өргөдөл ирээгүй бөгөөд шийдвэрлэлтийн явцад хугацаа хэтэрч шийдвэрлэсэн өргөдөл, гомдол байхгүй. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацаа 04 хоног 05 цаг 42 минут байна	100
62	Арга хэмжээ-3.1.5 “Архив, албан хэрэг хөтлөлтийн нийтлэг журам”-ын хүрээнд тавигдах стандарт, бүрдэл, шаардлагын дагуу 2025 оны архивын материалыг хүлээн авах, архивын баримтын нэгдсэн данс бүртгэл хөтлөх	-	Хадгаламжийн нэгжийн тоо	172	175	Нийт албан хаагчдаас архивын хадагаламжийн нэгж хүлээн хуваарийн дагуу 2025 онд үүссэн хадгаламжийн нэгжүүдийг бүрэн бүрдэлтэйгээр журмын дагуу хүлээн авч, Байнга хадгалах 70, Түр хадгалах 76, 70 жил хадгалах 6 нийт 152 баримтыг ач холбогдлын дарааллаар байгууллагын архивын санд байршуулан баримтын нэгдсэн данс бүртгэлд бүртгэсэн.	90

63	Арга хэмжээ-3.1.6 Байгууллагын үйл ажиллагааны талаарх сэтгэл ханамжийн судалгаа болон эвент арга хэмжээний судалгааг гадаад, дотоодын иргэдээс авч, түүний мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулах	-	Судалгаанд хамрагдсан хүний тоо	1900	2000	Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, Улаанбаатар хотын аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглээр 3 удаагийн судалгааг зохион байгуулж 514 хүнийг хамруулсан. Үүнд: ✓ Жуулчдыг Улаанбаатар хотод аюулгүй, ая тухтай аялах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор жуулчдаас аюулгүй байдлын талаарх судалгааг нийт 142 жуулчин (англи хэл дээр-21, Япон-6, Герман-7, Орос-3, Солонгос-3, Хятад-2)-аас авсан. ✓ Жуулчин тээврийн автобусны зогсоолын тоог нэмэгдүүлэх, голлох маршрутын дагуух түр зогсоолын асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор Монголын Зочид Буудлуудын Холбоо, Аялал жуулчлалын мэргэжлийн холбоодтой хамтран 152 гишүүн байгууллагаас судалгаа авч нэгтгэн саналыг авч Нийслэлийн Нийтийн тээврийн бодлогын газарт хүргүүлсэн. ✓ Талын салхи олон улсын мото наадам арга хэмжээний үеэр гадаадын 40 жуулчин, арга хэмжээнд оролцогч болон сонирхогч 180 хүнээс судалгаа авсан.	30
64	Арга хэмжээ-3.1.7 Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу байнга ил тод байлгах мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсанд хууль тогтоомжоор хүлээсэн үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаа, тайлан холбогдох цаг үеийн мэдээ, мэдээллийг нээлттэй байршуулах	-	Байршуулсан мэдээ, мэдээллийн тоо	2832	3000	Байгууллагын https://tourism.ub.gov.mn/ цахим хуудас болон мэдээллийн самбарт эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүнг эмх цэгцтэй, ойлгомжтой байдлаар байршуулан байнга шинэчилж, баяжуулалтыг тухай бүр хөтлөн явуулж Байгууллагын үйл ажиллагаа, арга хэмжээ болон салбарын холбогдолтой 464 мэдээ, мэдээлэл бэлтгэж газрын веб сайт болон пэйж хуудаст нийтэлж, эдгээр мэдээ мэдээллийг 7 телевиз, өдөр тутмын сонин 8, 25 веб сайтад давхардсан тоогоор 50 гаруй мэдээ нийтлүүлж ажилласан байна. Түүнчлэн телевизүүдээр байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 14 мэдээ, сурвалжилга, нэвтрүүлэг цацагдсан байна.	70

Дөрөв. Бизнес эрхлэгчдийг дэмжих жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

4.1.Зорилтод жилийн хүрээнд үндэсний үйлдвэрлэгч, жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч нар болон аялал жуулчлалын байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах

65	Арга хэмжээ-4.1.1 Жуулчдад зориулсан аялал жуулчлалын арга хэмжээнүүдэд бизнес эрхлэгчид, үйлчилгээний байгууллагуудын хамруулах, дэмжлэг үзүүлэх	-	Бизнес эрхлэгчдийн тоо	500	550	Нийслэлийн Засаг даргын 2026 оны А/01 дүгээр захирамжаар 2026 оныг “Бизнес эрхлэгчдийг дэмжих жил” болгон зарласантай холбогдуулан гадаад, дотоодын иргэд, жуулчдад зориулан зохион байгуулсан “Талын Жавхаа”, “Улаанбаатарын өвлийн наадам”, “Улаанбаатар өвлийн явган алхалтын фестиваль”, “Бүргэдийн баяр”, “Наурызын баяр”, “Плэйтийм пре эвент” хөгжмийн наадам, “UB food” олон улсын хоолны фестиваль “Бурхан багшийн дүйчин өдөр”, “Талын салхи” олон улсын мото наадам зэрэг 9 арга хэмжээний үеэр 223 жижиг, дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн худалдаа, үйлчилгээг гаргаж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан. Мөн Аялал жуулчлалын салбар, үндэсний үйлдвэрлэгчид болон жижиг, дунд бизнес эрхлэгчдийн түншлэл, хамтын ажиллагааг дэмжих зорилгоор Эдийн засаг хөгжлийн яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Жижиг, дунд үйлдвэрийн газар, Монголын Аялал жуулчлалын холбоотой хамтран “FEEL MONGOLIA-2026” арга хэмжээг 03 дугаар сарын 27, 28-ны өдрүүдэд зохион байгуулж, арга хэмжээнд үндэсний үйлдвэрлэгчид, үйлчилгээний бизнес эрхлэгчид, соёлын бүтээлч үйлдвэрлэл, эвент арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, ханган нийлүүлэгчид, зочид буудал, тур оператор зэрэг 250 гаруй аж ахуйн нэгж байгууллага, бизнес эрхлэгчид оролцон үйл ажиллагаагаа сурталчлан танилцууллаа.	100
66	Арга хэмжээ-4.1.2 Үзэсгэлэн, арга хэмжээнүүдэд аялал жуулчлалын байгууллагуудыг хамруулах	-	Бизнес эрхлэгчдийн тоо	10	50	“Монголд зочлох жил”-ийн хүрээнд Монгол Улс, Улаанбаатар хотыг гадаадад сурталчлах, зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор Аялал жуулчлалын мэргэжлийн холбоотой хамтран “ITB Berlin”, “ITB China Shanghai”, “Улаанбаатар травел експо 2026”, “SITF 2026”, “ITE Hongkong” зэрэг 5 олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд 82 аж ахуй нэгж байгууллагыг хамруулсан.	100
67	Арга хэмжээ-4.1.3 Дүүргүүдийн тодорхой байршлуудад жуулчдад зориулсан арга хэмжээг тогтмол зохион байгуулж,	-	Жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоо	-	600	Налайх дүүргийн Засаг даргын Тамгын газартай хамтран байгалийн самар, жимсийг гар дээрээс ил задгай худалдаалдаг 30 иргэнийг нэгдсэн зохион байгуулалтад оруулж, дүүргийн аялал жуулчлалын цогцолборт үйл ажиллагаа явуулж байна.	50

	жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг хамруулах					Баянгол дүүргийн Засаг даргын Тамгын газар болон “Жижиг, дунд үйлдвэр, үйлчилгээг дэмжих төв” ОНӨТҮГ-ын дэмжлэгтэйгээр “Баянголд үйлдвэрлэв” төвийг шинээр ажиллуулж, жижиг, дунд үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч 77 иргэн, аж ахуйн нэгжийг хамруулж үйл ажиллагааг нь дэмжин ажилласан. Мөн Дүүргийн Засаг даргын 2026 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн А/280 дугаар захирамжаар улирлын чанартай худалдаа, явуулын үйлчилгээтэй түргэн хоолны 145 үйлчилгээ эрхлэгчдэд байршил заан дэмжин ажиллаж байна.	
68	Арга хэмжээ-4.1.4 Аялал жуулчлалын байгууллагуудыг хөнгөлөлттэй зээлд хамруулахад дэмжлэг үзүүлэх	Улсын төсөв	Байгууллагын тоо	-	10	Монгол Улсын Засгийн газрын хуралдаанаар дөрвөн улирлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдэх дэд бүтцийн бүтээн байгуулалтыг эрчимжүүлэх зорилгоор аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдэд арилжааны банкнуудын эх үүсвэрт тулгуурлан 6.0 хувийн хүүтэй, 6 жил хүртэлх хугацаатай хөнгөлөлттэй зээл олгох “Аялал жуулчлалын салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээл олгох тухай” Засгийн газрын 2025 оны 255 дугаар тогтоол батлагдсан. Хөнгөлөлттэй зээлд хамрагдах хүсэлт гаргасан 2 жуулчны бааз, 1 зочид буудлын хүсэлтийг Соёл, спорт аялал жуулчлал, залуучуудын яаманд хүргүүлсэн.	50
69	Арга хэмжээ-4.1.5 Зочлох үйлчилгээний байгууллагуудын чанар стандартыг сайжруулах сургалт зохион байгуулах	-	Зохион байгуулсан сургалтын тоо	-	8	Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын чанар, хүртээмжийг сайжруулах, салбарын хүний нөөцийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Аялал жуулчлалын салбар дахь татвар-даатгал-байгууллагын менежмент, үнэ бодолт” сэдэвт сургалт, “Зочид буудал, дэн буудал, амралтын газар тавигдах ерөнхий шаардлага (MNS 4588:2008, MNS 6043:2019, MNS 6043:2019) стандарт” сэдэвт сургалт, “Гамшгаас урьдчилан сэргийлэх, аюулгүй байдлыг хангах нь” “Жуулчны хөтөч тайлбарлагчид ур чадвар олгох сургалт” зэрэг 4 төрлийн 3 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт 328 хүнийг хамруулав.	50
70	Арга хэмжээ-4.1.6 Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын	-	Хамруулсан байгууллагын тоо	-	3	Монгол Улсын дэд бүтцийн сайд (хуучин нэрээр)-ын 2002 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн “Журам батлах тухай” 150 дугаар тушаалаар батлагдан мөрдөгдөж	70

үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор одны зэрэглэл тогтоох журмын хүрээнд үйлчилгээний байгууллагуудыг хамруулах					байсан журмыг шинэчлэн боловсруулж Монгол улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар тогтоолоор “Аялал жуулчлалын үйлчилгээний байгууллагын ангилал, зэрэглэлийг тогтоох, олгох, бууруулах, хүчингүй болгох болон уг үйл ажиллагааны хөлстэй холбоотой журам” нэртэйгээр батлуулаад байна. Одоогоор зэрэглэл тогтоолгох хүсэлт гаргасан байгууллага байхгүй байна.	
Хэрэгжилтийн дундаж 80 хувь						

ТАНИЛЦСАН:
ДАРГА



Д.БАТСҮХ

ХЯНАСАН:
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН
ДАРГА

Д.ГАНБОЛД

ТАЙЛАН НЭГТГЭСЭН:
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ТАЙЛАН, ТОГТООЛ ШИЙДВЭР,
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ ХАРИУЦСАН АХЛАХ
МЭРГЭЖИЛТЭН

О.НЯМБАТ